

# Судлаачид Шүүхийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байна: ШЕЗ-ийн бүрэлдэхүүнд хэн багтах вэ?

IKON.MN

2020 ОНЫ 5 САРЫН 6

ЖИРГЭХЖИРГЭХ 55ХУВААЛЦАХ

IKON.MN



Нээлттэй Нийгэм Форумын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөр (хөтөлбөрийн мэдээллийг [www.forum.mn](http://www.forum.mn)) “Оюуны Инноваци” эрх зүйн судалгааны ТББ хамтран УИХ-ын хаврын чуулганаар Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх гэж буйтай холбогдуулан Шүүхийн тухай хуулийн төслийн талаарх бодлогын цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж байна.

Шүүх эрх мэдлийн хүрээний томоохон эрх зүйн шинэтгэлд олон нийт, хөндлөнгийн судлаачдын оролцоог хангах зорилготой Шүүхийн тухай хуулийн төслийн талаарх цуврал хэлэлцүүлгийн эхний дугаар "Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүний талаарх зохицуулалт" сэдвээр боллоо.

Хэлэлцүүлгийн зочноор "Оюуны Инноваци" ТББ-ын судлаач, хуульч П.Баттулга, Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн, МУИС-ийн ХЗС-ийн багш Т.Мөнх-Эрдэнэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн Захиргаа удирдлагын газрын дарга Ж.Сайнхишиг, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар оролцож УИХ-д өргөн баригдаад буй Шүүхийн тухай хуулийн төслийн талаарх өөрсдийн зүгээс санал, байр сууриа илэрхийлж байна.

**Тэдний хэлсэн онцлох эшлэлүүд:**



The infographic features two logos at the top left: a stylized 'O' and a circular logo with the text 'Оюуны Инноваци'. A date stamp in the top right corner reads 'Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05'. The main title is 'ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ'.

Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05

## ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн”



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн Т.Мөнх-Эрдэнэ

“ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг УИХ-ын 2020 оны 2 дугаар тогтоолоор баталсан. Тэр хуваарийн дагуу Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг үзэл баримтлалын хувь яаж хийх ёстой вэ гэдэг удирдамжийг хууль тогтоогчид өгсөн байгаа.

Тэр дотроос үзвэл Шүүхийн ерөнхий зөвлөлийг институтийн тэгш оролцоог хангах байдлаар хуульчлах ёстой гэсэн удирдамж байгаа. Үүний дагуу Ерөнхийлөгчийн өргөн барьсан төслийг боловсруулсан. ”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05

## ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн”



“Оюуны-Инноваци”  
ТББ-ын гүйцэтгэх  
захирал П.Баттулга

“

Одоогийн Шүүхийн захиргааны тухай хуульд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн 5 гишүүний нэгийг Монголын Хуульчдын Холбооноос санал болгож байгаа. Энэ уламжлалаа хадгалаад Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 5 гишүүнд Монголын Хуульчдын Холбооны төлөөллийг оруулахаар Шүүхийн тухай хуулийн төсөлд тусгах.

”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05

## ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн”



ХЗДХЯ-ны Хууль зүйн  
боллогын газрын дарга  
П.Сайнзориг

“

Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Хууль зүйн Байнгын хороноос нэр дэвшүүлэх шаардлагагүй гэж үзэж байгаа бол энийг Улсын Их Хурлаас байгуулагдсан Хууль зүйн Байнгын хорооны ажлын хэсэг дээр хэлэлцээд “Мэргэжлийн холбоо” нь цаашид нэр дэвшүүлэх бололцоотой гэж харж байна.

”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05

## ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн”



ХЗДХЯ-ны Хууль зүйн  
боллогын газрын дарга  
П.Сайнзориг

“

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, өөрсдөө томилохоор Үндсэн хуульд заасан.

Энэ үзэл санааг Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл дээр суулгаж өгсөн. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсны байгууллага хэрэгжүүлэх “Шүүгчдийн зөвлөл” гэдэг институтийг байгуулья. Улсын дээд шүүх, анхан болон давж заалдах шатны шүүгчдийн олонх оролцсоноор “Шүүгчдийн зөвлөл” нь 5 шүүгчээ Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгож, томилох гэсэн үзэл санааг Шүүхийн тухай хуулийн төсөлд тусгасан.

”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05

## ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн”



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш,  
Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн  
Т.Мөнх-Эрдэнэ

“ Яагаад Хууль зүйн Байнгын хорооноос Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлж болохгүй гэвэл ХЗБХ улс төрийн байгууллага, ХЗБХ шүүх эрх мэдэлд томилгоо хийх ямар ч боломж байхгүй, томилгоо хийдэг эрхтэй субъект биш.

Тийм Ерөнхийлөгчөөс өргөн барьсан хуулийн төсөлд төрөөс хараат бус мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын Хуульчдын Холбооны оролцоог нэмэгдүүлэх нь зөв шийдэл байна гэж харсан. ”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05

## ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн”



МУИС-ийн Хууль зүйн  
сургуулийн багш,  
Шүүхийн ёс зүйн  
хорооны гишүүн  
Т.Мөнх-Эрдэнэ

“ Ерөнхийлөгчөөс өргөн барьсан төсөлд нэг чухал заалт байгаа. Энэ нь шүүх, шүүгчийн албаны болон ажил хэргийн нэр хүндийг хамгаалах эрх бүхий тусгай нэгжийг ШЕЗ-ийн ажлын албаны бүтцэд байхаар тусгасан.

Сүүлийн үеийн харамсалтай жишээнүүд байна, шүүхийн нэр хүнд рүү баримт нотолгоогүйгээр халддаг, шүүгчийн нэр хүндийг зохион байгуулалттайгаар унагаадаг. Үүнийг цааш нь байлгахгүйгээр шүүхийн болон шүүгчийн нэр хүндийг хамгаалах бие даасан нэгж ажиллах ёстой. ”



Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05

## ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн”



Шүүхийн ерөнхий зөвлөлийн Захиргаа удирдлагын газрын дарга Ж.Сайнхишиг

“

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс судалж үзээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 10 гишүүний тав нь шүүгчид дотроосоо сонгож, томилдог байх.

Бусад шүүгч бус таван гишүүний хувьд Хууль зүйн Байнгын хорооноос 2, Ерөнхийлөгч, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монголын Хуульчдын Холбооноос тус бүр нэг, нэг хүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж, бүрэн эрхийг нь баталгаажуулж, томилдог байх саналаа 2020.02.19-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хууль санаачлагчид хүргүүлсэн.

”





Цуврал хэлэлцүүлэг 2020.05.05

## ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

“Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн”



“Оюуны-Инноваци”  
ТББ-ын гүйцэтгэх  
захирал П.Баттулга

“ Шүүгч бус 5 гишүүний хувьд анхаарах зүйл байна. Жишээ нь: шүүгчээр ажиллаж байгаад ямар нэг шалтгаанаар албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, өөрийн хүсэлтээр, эрүүл мэндийн гэх мэт шалтгаанаар чөлөөлөгдсөн хүн 5 гишүүний нэгээр орж ирвэл тэнцвэртэй байдал нь яах вэ?

Нөгөөтээгүүр шүүхийн Тамгын газрын дарга хийж байсан хүн шүүгч бус 5 гишүүнд орж болох уу? энэ мэт хязгаарлалтуудыг харгалзаж, тэнцвэртэй байдлыг хангах талыг анхаараасай гэж бодож байна. ”

Нээлттэй Нийгэм Форум, “Оюуны Инноваци” ТББ хамтран зохион байгуулж буй цуврал хэлэлцүүлэг өнөөдөр 15.00 цагт “Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо” сэдвээр өрнөнө. Энэ хэлэлцүүлэгт Оюуны Инноваци” ТББ-ын судлаач П.Баттулга, Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн, хуульч, судлаач Л.Галбаатар, МУИС-ийн ХЗС-ийн профессор, доктор О.Мөнхсайхан, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар оролцож шинээр өргөн барьж буй хуулийн төслийн хүрээнд ямар өөрчлөлт орж байгаа талаар ярилцах юм.

2020 оны 5 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд “Шүүгчид хариуцлага тооцох механизм”, “Шүүхийн дотоод хараат бус байдал буюу Дээд шүүхийн эрх хэмжээ” сэдвийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөж буй бөгөөд iKon.mn болон ННФ-ын <https://www.facebook.com/OpenSocietyForum/> фэйсбүүк дэх хуудсаар шууд дамжуулан хүргэх юм.

Хэлэлцүүлэг тус бүрт шинээр боловсруулсан хуулийн төслүүдийн ажлын хэсгийн гишүүд, хараат бус судлаачид оролцож санал шүүмжээ хуваалцана.

Цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч уламжлалт бодлогын хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулах боломж хязгаарлагдмал байгаа ч нийгмийн сүлжээний сувгаар сонирхсон иргэд, бодлого боловсруулагчдад хүргэхийг зорьж буй.

Иймд сонирхсон иргэд асуулт илгээж, санал шүүмж ирүүлэх бүрэн боломжтой.